АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

Хотонт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2024/74-НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www. open.audit.mn<br>Архангай аймаг<br>2024 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:<br>Бизкон аудит ХХК Архангай аймаг дахь салбар<br>Ахлах аудитор Ч.Анхбаяр<br>Утас: 8511-6555<br>Цахим хаяг: ankha964@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ..... 3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ..... 10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ..... 10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ..... 10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..... 11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 12
3.5.1 Төсвийн төлөвлөлт ..... 12
3.5.2 Төсвийн гүйцэтгэл ..... 12
3.5.3 Нэмэлт төсөв ..... 13
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн ..... 13
3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл ..... 13
4. АУДИТЫН ТАЙЛАН ..... 13
4.1 Ерөнхий зүйл ..... 13
4.2 Материаллаг байдал ..... 13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ..... 14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 14
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн ..... 14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..... 15
5.1 Төлбөрийн акт ..... 15
5.2 Албан шаардлага ..... 15
5.3 Зөвлөмж ..... 16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ..... 17

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| БГАҮТХ | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж |
| БШУЯ | Боловсрол шинжлэх ухааны яам |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| БШУГ | Боловсрол шинжлэх ухааны газар |

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024.02.25 № 99

танай ______________-ны №______________-т

ХОТОНТ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Ц.ГАНЧИМЭГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Хотонт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хотонт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд БШУЯ-аас хандив тусламжаар 338.4 мянган төгрөгийн бараа материал, 163,116.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй авсныг тайланд тусгасан байна.

**Аудитын гол асуудал**

“Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын дагуу тус байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэн баталсан байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 26.8 хувиар өссөн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 үндсэн зорилтын хүрээнд 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг БШУГ-аас 90.0 хувьтай үнэлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 146,294,613.37 | 261,255,368.37 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 23,248,576.86 | 148,894,537.86 |
| 312 | Банканд байгаа бэлэн мөнгө | 23,248,576.86 | 148,894,537.86 |
| 3121 | Төгрөг | 23,248,576.86 | 148,894,537.86 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 23,248,576.86 | 148,894,537.86 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 123,046,036.51 | 112,360,830.51 |
| 351 | Түүхий эд материал | 8,998,200.00 | 8,998,200.00 |
| 35130 | Эм боох материал | 8,998,200.00 | 8,998,200.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 3,900.00 | 345,050.00 |
| 354 | Хангамжийн материал | 114,043,936.51 | 103,017,580.51 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 14,986,926.00 | 13,325,420.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 97,728,170.51 | 85,388,570.51 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,180,000.00 | 1,800,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 148,840.00 | 2,503,590.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,728,188,648.12 | 1,815,355,321.97 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,728,188,648.12 | 1,815,355,321.97 |
| 392 | Биет хөрөнгө | 1,674,838,648.12 | 1,762,005,321.97 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,897,737,089.69 | 1,936,014,602.69 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | - 382,614,280.90 | - 482,149,360.90 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 12,450,000.00 | 10,500,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | - 6,150,000.00 | - 5,250,000.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 198,432,198.89 | 184,239,228.60 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | - 102,307,331.29 | - 33,345,379.38 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 164,655,381.23 | 115,731,170.29 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | - 152,916,309.46 | - 11,525,499.84 |
| 39217 | Ном | 45,551,899.96 | 47,790,560.51 |
| 393 | Биет бус хөрөнгө | 53,350,000.00 | 53,350,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 53,350,000.00 | 53,350,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,874,483,261.49 | 2,076,610,690.34 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 4,764,523.00 | - |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 4,764,523.00 | - |
| 413 | Өглөг | 4,764,523.00 | - |
| 4136 | Бусад өглөг | 4,764,523.00 | - |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 4,764,523.00 | - |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,869,718,738.49 | 2,076,610,690.34 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,869,718,738.49 | 2,076,610,690.34 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,907,505,089.32 | 1,907,505,089.32 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,907,505,089.32 | 1,907,505,089.32 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | - 693,240,994.77 | - 486,349,042.92 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | - 693,240,994.77 | - 693,240,994.77 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 206,891,951.85 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 655,454,643.94 | 655,454,643.94 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,874,483,261.49 | 2,076,610,690.34 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 3,529,006,236.60 | 2,237,029,137.75 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,920,065,936.60 | 167,723,537.75 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,920,065,936.60 | 167,723,537.75 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,968,100.00 | 4,268,200.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,968,100.00 | 4,268,200.00 |
| 120009 | Бусад орлого | | 97,922,100.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - үндсэн хөрөнгө | 1,789,570,890.09 | 65,194,822.75 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - бараа материал | 126,526,946.51 | 338,415.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,608,940,300.00 | 2,069,305,600.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,457,291,900.00 | 1,983,146,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 1,983,146,200.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,457,291,900.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 160,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 160,000.00 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 151,488,400.00 | 86,159,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 151,488,400.00 | 86,159,400.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,659,287,498.11 | 2,030,137,185.90 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,659,287,498.11 | 2,030,137,185.90 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,583,867,304.18 | 1,957,479,115.90 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,032,323,746.21 | 1,309,696,237.00 |
| 210101 | Үндсэн цалин | 722,903,122.00 | 872,613,831.00 |
| 210102 | Нэмэгдэл | 228,559,963.00 | 354,251,293.00 |
| 210104 | Урамшуулал | 80,860,661.21 | 82,831,113.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 131,340,763.00 | 174,173,800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 89,477,807.31 | 118,437,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,526,669.88 | 13,933,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,421,399.83 | 11,147,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,083,207.88 | 2,787,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,831,678.10 | 27,868,200.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 68,167,123.00 | 75,347,691.91 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 22,414,652.00 | 25,497,541.91 |
| 210302 | Түлш, халаалт | 45,452,471.00 | 49,550,150.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 300,000.00 | 300,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 13,009,321.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | | 13,009,321.00 |
| 2105 | Нормативт зардал | 171,270,300.00 | 198,437,540.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,470,150.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | 168,800,150.00 | 198,437,540.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,087,000.00 | 1,213,690.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,087,000.00 | 1,213,690.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 12,461,182.00 | 12,551,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,743,800.00 | 4,121,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 6,717,382.00 | 8,429,800.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 166,217,189.97 | 173,049,835.99 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 33,723,298.00 | 37,685,667.09 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 15,767,650.00 | 17,537,920.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 116,726,241.97 | 117,826,248.90 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 75,420,193.93 | 72,658,070.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 71,679,670.00 | 72,658,070.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 71,679,670.00 | 72,658,070.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 3,740,523.93 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,740,523.93 | - |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 1,869,718,738.49 | 206,891,951.85 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 1,869,718,738.49 | 206,891,951.85 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 1,612,908,400.00 | 2,073,573,800.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 3,968,100.00 | 4,268,200.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 3,968,100.00 | 4,268,200.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,968,100.00 | 4,268,200.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,968,100.00 | 4,268,200.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,608,940,300.00 | 2,069,305,600.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,457,291,900.00 | 1,983,146,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 1,983,146,200.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,457,291,900.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 160,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 160,000.00 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 151,488,400.00 | 86,159,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 151,488,400.00 | 86,159,400.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1,534,315,823.14 | 1,906,051,839.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,534,315,823.14 | 1,906,051,839.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,459,309,509.21 | 1,833,050,319.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,032,323,746.21 | 1,309,696,237.00 |
| 210101 | Үндсэн цалин | 722,903,122.00 | 872,613,831.00 |
| 210102 | Нэмэгдэл | 228,559,963.00 | 354,251,293.00 |
| 210104 | Урамшуулал | 80,860,661.21 | 82,831,113.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 131,340,763.00 | 174,173,800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 89,477,807.31 | 118,437,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,526,669.88 | 13,933,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,421,399.83 | 11,147,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,083,207.88 | 2,787,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,831,678.10 | 27,868,200.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 64,332,600.00 | 83,600,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 22,414,652.00 | 25,433,611.01 |
| 210302 | Түлш, халаалт | 41,617,948.00 | 56,118,238.99 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 300,000.00 | 2,048,150.00 |
| 2105 | Нормативт зардал | 168,629,600.00 | 199,934,040.00 |
| 210502 | Хоол, хүнс | 168,629,600.00 | 199,934,040.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,559,400.00 | 2,559,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,559,400.00 | 2,559,400.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 13,727,000.00 | 14,140,600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,968,100.00 | 4,268,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 9,758,900.00 | 9,872,400.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 46,396,400.00 | 48,946,242.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 31,758,000.00 | 34,137,642.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 14,638,400.00 | 14,808,600.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 75,006,313.93 | 73,001,520.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 71,265,790.00 | 73,001,520.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 71,265,790.00 | 73,001,520.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 3,740,523.93 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,740,523.93 | - |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 78,592,576.86 | 167,521,961.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 55,344,000.00 | 41,876,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 55,344,000.00 | 41,876,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 55,344,000.00 | 41,876,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 55,344,000.00 | 41,876,000.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | - 55,344,000.00 | - 41,876,000.00 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 23,248,576.86 | 125,645,961.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 23,248,576.86 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 23,248,576.86 | 148,894,537.86 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,907,505,089.32 | 655,454,643.94 | - 754,561,681.62 | 1,808,398,051.64 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | -1,808,398,051.64 | -1,808,398,051.64 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 1,869,718,738.49 | 1,869,718,738.49 |
| C08 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,907,505,089.32 | 655,454,643.94 | - 693,240,994.77 | 1,869,718,738.49 |
| D01 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 1,907,505,089.32 | 655,454,643.94 | - 693,240,994.77 | 1,869,718,738.49 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 206,891,951.85 | 206,891,951.85 |
| D09 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,907,505,089.32 | 655,454,643.94 | - 486,349,042.92 | 2,076,610,690.34 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,100,243,400.00 | 1,947,927,839.00 | 152,315,561.00 | 92.75 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,100,243,400.00 | 1,947,927,839.00 | 152,315,561.00 | 92.75 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,014,051,900.00 | 1,874,926,319.00 | 139,125,581.00 | 93.09 |
| 2,101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,435,021,000.00 | 1,309,696,237.00 | 125,324,763.00 | 91.27 |
| 210101 | Үндсэн цалин | 961,578,000.00 | 872,613,831.00 | 88,964,169.00 | 90.75 |
| 210102 | Нэмэгдэл | 402,474,300.00 | 354,251,293.00 | 48,223,007.00 | 88.02 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210104 | Урамшуулал | 70,968,700.00 | 82,831,113.00 | -11,862,413.00 | 116.71 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 179,377,700.00 | 174,173,800.00 | 5,203,900.00 | 97.1 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 121,976,800.00 | 118,437,800.00 | 3,539,000.00 | 97.1 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 14,350,200.00 | 13,933,400.00 | 416,800.00 | 97.1 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 11,480,200.00 | 11,147,200.00 | 333,000.00 | 97.1 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,870,100.00 | 2,787,200.00 | 82,900.00 | 97.11 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 28,700,400.00 | 27,868,200.00 | 832,200.00 | 97.1 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 83,600,000.00 | 83,600,000.00 | - | 100.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,000,000.00 | 25,433,611.01 | 15,433,611 .01 | 254.34 |
| 210302 | Түлш, халаалт | 67,000,000.00 | 56,118,239.99 | 10,881,761.01 | 83.76 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,600,000.00 | 2,048,150.00 | 4,551,850.00 | 31.03 |
| 2105 | Норматив зардал | 201,774,700.00 | 199,934,040.00 | 1,840,660.00 | 99.09 |
| 210502 | Хоол, хүнс | 201,774,700.00 | 199,934,040.00 | 1,840,660.00 | 99.09 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,559,400.00 | 2,559,400.00 | - | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,559,400.00 | 2,559,400.00 | - | 100.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 17,561,400.00 | 14,140,600.00 | 3,420,800.00 | 80.52 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,689,000.00 | 4,268,200.00 | 3,420,800.00 | 55.51 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 9,872,400.00 | 9,872,400.00 | - | 100.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 94,157,700.00 | 90,822,242.00 | 3,335,458.00 | 96.46 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 79,349,100.00 | 76,013,642.00 | 3,335,458.00 | 95.80 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 14,808,600.00 | 14,808,600.00 | - | 100.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 86,191,500.00 | 73,001,520.00 | 13,189,980.00 | 84.70 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 86,191,500.00 | 73,001,520.00 | 13,189,980.00 | 84.70 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 86,191,500.00 | 73,001,520.00 | 13,189,980.00 | 84.70 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,100,243,400.00 | 2,073,573,800.00 | 26,669,600.00 | 99.63 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,983,146,200.00 | 1,983,146,200.00 | - | 100.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,983,146,200.00 | 1,983,146,200.00 | - | 100.00 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 86,159,400.00 | 86,159,400.00 | - | 100.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 86,159,400.00 | 86,159,400.00 | - | 100.00 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 7,689,000.00 | 4,268,200.00 | 3,420,800.00 | 0.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 7,689,000.00 | 4,268,200.00 | 3,420,800.00 | 0.00 |
| 131009 | Оны эхний үлдэгдлээс санхүүжүүлэх | 23,248,800.00 | | 23,248,800.00 | |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 23,248,577.00 | -23,248,577.00 | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 148,894,538.00 | 148,894,538.00 | |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 610,001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 80.00 | 80.00 | - | 100.00 |
| 620,001 | Удирдах ажилтан | 3.00 | 3.00 | - | 100.00 |
| 620,002 | Гүйцэтгэх ажилтан | 45.00 | 45.00 | - | 100.00 |
| 620,003 | Үйлчлэх ажилтан | 32.00 | 32.00 | - | 100.00 |
| 63 | СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР) | 716 | 720 | -4 | 100.50 |
| 630 | ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД | 716 | 720 | -4 | 100.50 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 716 | 720 | -4 | 100.50 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 52,000.0 мянган төгрөгийн 1 алдаа[1] илэрснийг залрууллаа.

Залруулсан алдаа:

- Орон нутгийн өмчийн газраас орлогод авч бүртгэх шийдвэр гараагүй байхад улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн цэвэрлэх байгууламжийг 52,000.0 мянган төгрөгөөр бүртгэснийг данснаас хасаж залруулсан.

Аудитаар нийт 11,220.0 мянган төгрөгийн 3 зөрчил[2] илэрснээс, 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 1 зөвлөмжийг хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй 11,220.0 мянган төгрөгийн материаллаг зөрчилтэй асуудал илэрсэн нь гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 14,208.6 мянган төгрөгөөс бага байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

### 3.1 Төлбөрийн акт

**5.1.1** Цалингийн санд хоол, унааны зардал/210103/ батлагдаагүй, мөн байгууллагын дотоод журамд жилд 1 удаа олгоно гэсэн заалтыг зөрчиж 12-р сард 11,220.0 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлт олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5.-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 10 сарын 29-ний өдрийн 190 дугаар тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал" 210103 Унаа хоолны хөнгөлөлт гэсэн эдийн засгийн ангилалд “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журамд заасны дагуу ажилдаа ирэх, буцахад нийтийн тээврийн унааны зардлыг 50 хувийг олгох, мөн өдрийн хоолны хөнгөлөлтийг энэ ангилалд бүртгэнэ”,Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 6-д "Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагад энэ хуулийн 44.5.1, 46.3 хамаарахгүй", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3. "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

_Шийдвэрлэсэн нь_: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

### 3.2 Албан шаардлага

5.2.1 Бараа үйлчилгээний бусад зардал, БҮТЭЗ худалдан авахдаа гэрээ байгуулаагүй худалдан авалтыг хийсэн байна.

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5. "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно." 13.6. "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

_Шийдвэрлэсэн нь_: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

**3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**5.3.1** Бараа материалтай холбоотой асуудал

_Илрүүлэлт:_ Үндсэн хөрөнгийн номын фондод бүртгэлтэй нийт 47,790.0 мянган төгрөгийн номоос 6-12 дугаар ангийн сурах бичгийг ялгаж аж ахуйн бүртгэлд шилжүүлэн бүртгэх зөвлөмжийн хүргүүллээ.

Энэ нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт " 4.16 Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг стандартыг мөрдөнө." гэсэн заалтыг зөрчсөн байна.

_Өгсөн зөвлөмж_: Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын заавар маягтын дагуу бараа материалын аж ахуйн материалд бүртгэх арга хэмжээ авах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 03 дугаарын 22-ны дотор ирүүлнэ үү.

*Зөвлөмжийн биелэлтийг тооцож, нотлох баримтыг хангуулан 2024 оны 06 дугаар сарын 20-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | То о | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | То о | Дүн | Тоо | Дүн |
| Хөрөнгөд бүртгэх шийдвэргүйгээр улсын төсвөөр хийгдсэн хөрөнгө оруулалтыг бүртгэсэн | 1 | 52,000.0 | | | 1 | 52,000.0 | 1 | 52,000.0 | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | 1 | 52,000.0 | | | 1 | 52,000.0 | 1 | 52,000.0 | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Цалингийн санд хоол унааны хөнгөлөлт батлагдаагүй байхад хоол унааны хөнгөлөлт олгосон | 1 | 11,220.0 | 1 | 11,220.0 | | | | | | | | |
| Гэрээ байгуулаагүй худалдан авалт хийсэн | 1 | 0 | | | 1 | 0 | | | | | | |
| Сурах бичгийг ялгаж аж ахуйн бүртгэлд шилжүүлэн бүртгээгүй | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| Дүн | 3 | 11,220.0 | 1 | 11,220.0 | 1 | 0 | 1 | 0 | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |